

2018 оны II улирал

НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2018
оны II улирлын санхүүгийн тайлангийн
нэгтгэлийн танилцуулга

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага
тойруу 3, Засгийн газрын IV байр. Утас: 51-261668

Агуулга

1. Салбарын өнөөгийн байдал	1
1.1 Ерөнхий төлөв байдал	1
1.2 Статистик үзүүлэлтүүд	2
2. Активын бүтэц, зээлийн үйл ажиллагаа	6
2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт	6
2.2 Зээл.....	8
2.2.1 Зээлийн зориулалт	8
2.2.2 Зээлийн багцын чанар	8
2.2.3 Зээлдэгчид	9
2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	10
3. Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	11
3.1 Өр төлбөр.....	11
3.2 Эздийн өмч	14
4. Орлого, үр дүнгийн тайлан.....	16
4.1 Орлого.....	16
4.2 Зарлага	17
4.3 Ашигт ажиллагаа	17
5. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	18
5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	18
5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	18
5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	19
6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	21
6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд	21
6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	22
6.3 Гадаад валютын арилжааны ББСБ-ууд	23
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ	25
ДҮГНЭЛТ.....	25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл.....	1
Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо.....	2
Хүснэгт 5 Харилцагчид.....	2
Хүснэгт 6 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/.....	3
Хүснэгт 7 ББСБ-уудын тархалт /хот/.....	4
Хүснэгт 8 ББСБ-уудын тархалт /орон нутаг, бүсээр/.....	4
Хүснэгт 9 Активын бүтэц /сая төгрөгөөр/.....	6
Хүснэгт 10 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/.....	6
Хүснэгт 11 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/.....	8
Хүснэгт 12 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/.....	9
Хүснэгт 13 Ерөнхий статистик /харилцагчид/.....	9
Хүснэгт 14 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/.....	11
Хүснэгт 15 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 16 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/.....	13
Хүснэгт 17 Мөнгөн гуйвуулга болон төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй ББСБ-ууд /мян.төг/.....	13
Хүснэгт 19 Бусад пассив /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 20 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/.....	15
Хүснэгт 21 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая,төг/.....	16
Хүснэгт 22 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	17
Хүснэгт 23 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ.....	18
Хүснэгт 24 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ.....	18
Хүснэгт 25 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ.....	19
Хүснэгт 26 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл.....	21
Хүснэгт 27 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц.....	22
Хүснэгт 28 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц.....	22
Хүснэгт 29 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл.....	22
Хүснэгт 30 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив.....	23
Хүснэгт 31 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив.....	23
Хүснэгт 32 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив.....	24
Хүснэгт 33 Орлогын бүтэц.....	24

Зургийн жагсаалт

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо.....	1
Зураг 2 Хорооны тогтоол /өссөн дүнгээр/.....	1
Зураг 3 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо.....	2
Зураг 4 Санхүүгийн програм ашиглалт.....	3
Зураг 5 Програмын төрлүүд /програмтай ББСБ-уудын хувьд/.....	4
Зураг 6 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт.....	4
Зураг 7 Мөнгөн хөрөнгийн бүрдэл /сүүлийн 5 жилээр/.....	6
Зураг 8 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая.төг/.....	7
Зураг 9 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая.төг/.....	7
Зураг 10 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/.....	7
Зураг 11 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/.....	8
Зураг 12 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/.....	8

Зураг 13 Зээлийн чанар.....	9
Зураг 14 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа.....	9
Зураг 15 Зээлдэгчдийн боловсрол.....	10
Зураг 16 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	10
Зураг 17 Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	11
Зураг 18 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	13
Зураг 19 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/.....	14
Зураг 20 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг.....	14
Зураг 21 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	14
Зураг 22 Ашигт ажиллагааны үзүүлэлт.....	16
Зураг 23 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	16
Зураг 24 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/.....	16
Зураг 25 Үндсэн бус үйл ажиллагааны орлого.....	17
Зураг 26 Ашигийн өсөлт /хувиар/.....	17
Зураг 27 Зохистой харьцаа.....	18
Зураг 28 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт.....	21
Зураг 29 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	22
Зураг 30 Хүүгийн бус зардлын бүтэц.....	24

1. Салбарын өнөөгийн байдал

1.1 Ерөнхий төлөв байдал

2018 оны II улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 539 ББСБ байна. Энэ нь 2017 оны II улирлаас 6 ББСБ буюу 1.1 хувь, оны эцсээс 5 ББСБ буюу 0.9 хувиар өссөн үзүүлэлт юм.


Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо



2018 оны II улирлын байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ байгаа бол хөдөө орон нутагт 75 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 оны эхний хагас жилд Хорооны хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлыг авч үзвэл:

Зураг 2 Хорооны тогтоол /өссөн дүнгээр/



- 10 хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох,
- 18 ББСБ-д 26 тусгай зөвшөөрөл нэмж олгох,
- 5 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох;
- 2 ББСБ-ын 3 төрлийн тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн хүчингүй болгох,
- 14 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь, 1 ББСБ-ын хэсэгчлэн түдгэлзүүлэх,
- 1 ББСБ-ын гадаад валют арилжааны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сэргээх,
- 2 ББСБ-ыг нэгтгэхийг зөвшөөрөх зэрэг асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

	2014-II	2015-II	2016-II	2017-II	2018-II
Шинээр олгосон	66	53	53	20	10
Хүчингүй	3	8	4	5	5
Түдгэлзүүлсэн	4	4	0	17	15
Сэргээсэн	0	3	1	0	2
Нийт ББСБ	326	423	499	533	539

2018 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбартай холбоотой Хорооны даргын 315 /II улиралд-127/ тушаал гарчээ. Үүнээс 293 /II улиралд-116/ тушаалаар 286 ББСБ /4 ББСБ 2 удаа өөрчлөлт оруулсан/ 100.4 тэрбум төгрөгөөр /II улиралд-52.8 тэрбум төгрөг/ хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж, 6 ББСБ оноосон нэрээ өөрчилсөн бол 13 ББСБ 28 /II улиралд-13/ салбар нээж, 1 ББСБ-ын 2 салбар хаах асуудлыг шийдвэрлэсэн байна.

Үйл ажиллагааны төрөл

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 2018 оны II улирлын байдлаар 539 ББСБ 9 төрлийн 775 тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын 90.9% буюу 490 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 66.2% буюу 357 ББСБ дагнан эрхэлж байгаа бол 28.2% буюу 152 ББСБ гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 8.5% буюу 46 ББСБ дагнан эрхэлж байна.

Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өсөлт	
		2017-II	2018-II	тоо	хувь
	Нийт ББСБ	533	539	6	1.1%
1	Зээл	480	490	10	2.1%
Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг		357	357	0	0
2	Факторингийн үйлчилгээ	22	20	-2	-9.1%
3	Төлбөрийн баталгаа гаргах	17	18	1	5.9%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	2	3	1	50.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	14	23	9	64.3%
6	Гадаад валютын арилжаа	147	152	5	3.4%
Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг		53	46	-7	-13.2%
7	Итгэлцлийн үйлчилгээ	27	29	2	7.4%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	6	9	3	50.0%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	31	31	0	0.0%


2018 оны II улиралд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ-уудын хувьд зээлийн үйл ажиллагааны 5, гадаад валютын арилжааны 1 тусгай зөвшөөрөл авсан бөгөөд, үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд 8 төрлийн 26 тусгай зөвшөөрөл нэмж авсан байна. Үүнд цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээний 7, зээлийн үйл ажиллагааны 5, гадаад валютын арилжаа 6, төлбөрийн баталгаа гаргах 3, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх 2, факторинг, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах болон итгэлцлийн үйлчилгээний тус тус 1 тусгай зөвшөөрөл нэмж авчээ. Мөн зээлийн үйл ажиллагаа 5, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх болон факторингийн тус тус 2, төлбөрийн баталгаа гаргах 1 тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон байна.

1.2 Статистик үзүүлэлтүүд

2018 оны II улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 539 ББСБ-аас 97.6% буюу 526 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд дор дурдсан нэр бүхий 13 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан байна.

2018 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 4793 хувь нийлүүлэгчдийн 539 ББСБ, 190 салбар нэгж, 4 төлөөлөгчийн газар, 2602 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,423,597 харилцагчдад хүрч үйлчилж байна.

Зураг 3 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо



• Харилцагчид

Нийт харилцагчдын 48.1% нь эмэгтэй, 51.8% нь эрэгтэй, 0.1% нь хуулийн этгээд байна. 87.7 хувийг 2 ББСБ-ын харилцагчид бүрдүүлж байна.

Хүснэгт 3 Харилцагчид

	ББСБ тоо	Хувь	Харилцагчдийн тоо	Хувь
100-аас доош	369	68.5%	13,640	1.0%
100-1000	129	23.9%	32,858	2.3%
1001-10,000	37	6.9%	107,615	7.6%
10,000-1,000,000	3	0.6%	76,947	5.4%
1,000,000-аас дээш	1	0.2%	1,192,537	83.8%
НИЙТ	539	100.0%	1,423,597	100.0%

Харилцагчдын 83.8 хувийг цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээгээрээ 1.2 сая хэрэглэгчтэй 1 ББСБ, цахим зээлийн аппликейшнээр дамжуулан хиймэл оюун ухаанд суурилсан санхүү, технологийн шийдлээр барьцаагүй, хурдан шуурхай, урамшуулалтай, цахим зээл олгох финтек үйлчилгээний 55,857 хэрэглэгчдээрээ 1 ББСБ ХХК нийт харилцагчдын 3.9 хувийг тус тус бүрдүүлж байна.

- Хувьцаа эзэмшигчид

2018 оны II улирлын байдлаар 539 ББСБ-ын 4793 хувьцаа эзэмшигч байна. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийг оролцуулалгүйгээр 1055 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байгаа ба энэ нь ББСБ-уудын 2017 оны жилийн эцсийн дүнгээс 0.6 хувиар, 2017 оны II улирлаас 1.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Статистик мэдээгээр ХХК-ийн 1055 хувьцаа эзэмшигчдийн 36.4% буюу 385 нь ХК-ийн 3738 хувьцаа эзэмшигчдийн 53.5% буюу 2000 нь эмэгтэй хүн байна.

Нийт 539 ББСБ-ын 296 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 237 ББСБ нь 2-9, 5 ББСБ нь 10-аас дээш хувьцаа эзэмшигчтэй байна.

- Ажиллагсад

539 ББСБ-д 2602 ажилтан ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 14.0 хувь буюу 320 ажилтнаар оны эхнээс 5.2 хувь буюу 129 ажилтнаар нэмэгдсэн дүн юм. Нийт ажилчдын 55.5% буюу 1443 нь эмэгтэй 1159 нь эрэгтэй ажилчид байгаа нь хүйсийн тэнцвэртэй байдлыг харуулж байна.

- Банкны салбартай харьцуулсан нь

Хүснэгт 4 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2017-II	2017-IV	2018-II
Нийт хөрөнгө	855.8	969.2	1,143.7
Банкны салбартай харьцуулахад хувиар	3.3%	3.4%	3.8%
Нийт өөрийн хөрөнгө	681.4	758.2	888.5
Банкны салбартай харьцуулахад хувиар	22.3%	24.1%	27.9%


Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	549.5	595.4	707.8
Банкны салбартай харьцуулахад хувиар	88.6%	89.9%	90.4%
Нийт зээл	554.9	638.0	768.3
Банкны салбартай харьцуулахад хувиар	4.3%	4.7%	5.0%
Нийт орлого	89.4	195.9	118.4
Нийт зарлага	61.3	129.1	71.9
Цэвэр ашиг	28.1	66.8	46.5

2018 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1,14 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.6 хувиар буюу 287.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 18 хувиар буюу 174.5 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм. Энэхүү өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28.8 хувиар буюу 158.3 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 18.9 хувиар буюу 112.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Активын өсөлттэй холбоотойгоор зээлийн өрийн эцсийн үлдэгдэл нь 2018 оны II улирлын байдлаар 768.3 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 38.5% буюу 213.4 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 20.4% буюу 130.3 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд нийт ББСБ-уудын 90.9% нь зээлийн үйл ажиллагааны эрхэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 32.4 хувиар буюу 29.0 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 17.3 хувиар буюу 10.6 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 65.5 хувиар буюу 18.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

- Програм ашиглалт

Зураг 4 Санхүүгийн програм ашиглалт



2018 оны II улирлын байдлаар 539 ББСБ-ын 326 нь буюу 61% нь үйл ажиллагаандаа санхүүгийн програм ашиглаж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 461 ББСБ-ын 292 нь буюу 63%, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 76 ББСБ-ын 45% нь санхүүгийн програмтай байна.


Хамгийн нийтлэг ашиглаж байгаа санхүүгийн програм нь “Ай Би Ай” ХХК-ийн Спинел болон Даймонд програм /121 ББСБ/, “Грейпсити” ХХК-ийн Ачидбанкир болон MARS програмууд /81 ББСБ/ байна.

Зураг 5 Програмын төрлүүд /програмтай ББСБ-уудын хувьд/

Програмын нэр	ББСБ тоо	Эзлэх хувь
IBI - Diamond, Spinel	121	37.6%
Ггаре city - Ачидбанкир, Марс	81	25.2%
Бусад	48	14.9%
ECM - E-FINANCE	24	7.5%
RS BANK	15	4.7%
EXCEL.MN	12	3.7%
"Интерактив" ХХК - Пирамид програм	12	3.7%
ЭЛЕКТРОМОН	9	2.8%
Нийт	322	100.0%

Тархалт

Зураг 6 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт



Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 86.1% буюу 464 ББСБ, салбаруудын 70.0% буюу 133 салбар байршиж байна. Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 67.0% буюу 311 ББСБ Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Налайх

дүүрэгт 1 ББСБ, 2 салбар, Багахангай дүүрэгт банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Нийт 3 ББСБ-ын 4 төлөөлөгчийн газар бүртгэлтэй байгаа ба Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Баянгол дүүрэг, Булган аймгийн Булган сум болон Америкийн Нэгдсэн улсын Вашингтон хотод тус тус байршиж байна.

Хүснэгт 5 ББСБ-уудын тархалт /хот/

Дүүрэг	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Сүхбаатар	166	17	183	30.7%
Чингэлтэй	145	21	166	27.8%
Баянгол	66	29	95	15.9%
Баянзүрх	47	37	84	14.1%
Хан-Уул	29	11	40	6.7%
Сонгинохайрхан	9	12	21	3.5%
Багануур	1	4	5	0.8%
Налайх	1	2	3	0.5%
Багахангай	0	0	0	0.0%
НИЙТ /хот/	464	133	597	100.0%

Орон нутагт нийт ББСБ-ын 14.1% буюу 76 ББСБ, салбаруудын 30.0% буюу 57 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 6 ББСБ-уудын тархалт /орон нутаг, бүсээр/

Бүс	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Хангайн бүс	24	22	46	34.8%
Төвийн бүс	22	15	37	28.0%
Зүүн бүс	14	8	22	16.7%
Баруун бүс	10	5	15	11.4%
Говийн бүс	5	7	12	9.1%
НИЙТ /орон нутаг/	75	57	132	100.0%

Нийт 61 ББСБ-ын 190 салбар бүртгэлтэй байгаа ба үүний 35.8 хувийг 5 ББСБ-ын 68 салбар бүрдүүлж байгаа бол 6-9 салбартай 5 ББСБ, 2-5 салбартай 19 ББСБ, 1 салбартай 34 ББСБ Улаанбаатар хотын 8 дүүрэг, Монгол улсын 15 аймагт үйл ажиллагаа явуулж байна.

2. Активын бүтэц, зээлийн үйл ажиллагаа

2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт

2018 оны II улиралд ББСБ-уудын актив 1.0 их наяд 144 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 33.6% буюу 287.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 18.0% буюу 174.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 7 Активын бүтэц /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2017-II	2017-IV	2018-II	Өөрчлөлт			
				оны эхэн		өмнөх оны мөн үе	
	дүн	дүн	дүн	дүн	хувь	дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	819,685.60	932,691.58	1,101,049.67	168,358.09	18.1%	281,364.07	34.3%
Мөнгөн хөрөнгө	232,837.91	264,057.75	277,115.11	13,057.36	4.9%	44,277.20	19.0%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	5,451.79	2,742.65	2,125.98	(616.68)	-22.5%	(3,325.81)	-61.0%
Нийт зээл	554,938.80	638,007.83	768,345.95	130,338.12	23.5%	213,407.15	38.5%
(Зээлийн эрсдэлийн сан)	47,373.16	56,005.83	57,788.69	1,782.86	3.8%	10,415.53	22.0%
Зээл (цэврээр)	507,565.64	582,002.00	710,557.26	128,555.26	22.1%	202,991.62	40.0%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	0.00	125.00	232.74	107.74	86.2%	232.74	-
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	6,011.19	8,110.65	9,821.35	1,710.70	21.1%	3,810.16	63.4%
Бусад хөрөнгө	67,819.06	75,653.52	101,197.23	25,543.71	33.8%	33,378.17	49.2%
Эргэлтийн бус хөрөнгө	36,101.69	36,487.42	42,646.69	6,159.27	16.9%	6,545.00	18.1%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр)	36,101.69	36,487.42	42,646.69	6,159.27	16.9%	6,545.00	18.1%
Нийт хөрөнгийн дүн	855,787.28	969,179.00	1,143,696.36	174,517.36	18.0%	287,909.08	33.6%

Салбарын нийт активын 96.3 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Эргэлтийн хөрөнгө оны эхнээс 18.1% буюу 168.4 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 34.3% буюу 281.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт активын 86.4% буюу 987.7 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө болон цэвэр зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 36 ББСБ нийт активын 43.1 хувийг, 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 361 ББСБ нийт активын 52.7 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 142 ББСБ нийт активын 4.3 хувийг эзэлж байна.

Активын гол өөрчлөлтүүдийг харвал цэвэр зээлийн үлдэгдэл оны эхнээс 22.1% буюу 128.6 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 40.0% буюу 202.9 тэрбум төгрөгөөр, мөнгөн хөрөнгө оны эхнээс 4.9% буюу 13.1 тэрбум төгрөгөөр, өмнөх


оны мөн үеэс 19.0% буюу 44.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 8 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/

Интервал	ББСБ тоо	Дүн	Эзлэх хувь
1 тэрбумаас доош	142	48.9	4.3%
1-4.9 тэрбум хүртэл	361	602.4	52.7%
5 тэрбум ба түүнээс дээш	36	492.4	43.1%
НИЙТ	539	1143.7	100%

- Мөнгөн хөрөнгө

Зураг 7 Мөнгөн хөрөнгийн бүрдэл /сүүлийн 5 жилээр/



Нийт активын 24.2% буюу 277.1 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байна. Үүнээс 150.1 тэрбум төгрөг буюу мөнгөн хөрөнгийн 54.2% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 84.0 тэрбум буюу 30.3% нь банк болон санхүүгийн байгууллагын харилцах дансанд, 43.0 тэрбум буюу 15.5% нь хадгаламжид байршиж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэлэн мөнгө 6.1 хувиар, хадгаламж 9.8 хувиар, харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө 60.9 хувиар өссөн байна.

- Богино хугацаат хөрөнгө оруулалт

2018 оны II улирлын байдлаар богино хугацаат хөрөнгө оруулалт нь нийт активын 0.2 хувийг бүрдүүлж байна. 20 ББСБ 2.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүний 93.5% буюу 1.9 тэрбум төгрөгийг 5 ББСБ-ын хөрөнгө оруулалт, 6.0% буюу 128.4 сая төгрөгийг 5 ББСБ-ын хөрөнгө оруулалт, 0.5 хувийг 10 ББСБ-ын тус бүр 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.


Цэвэр богино хугацаат хөрөнгө оруулалтын дүн оны эхнээс 22.5% буюу 616.7 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 61.0% буюу 3.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ.

Зураг 8 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая.төг/



Арилжааны үнэт цаасанд 64.3% буюу 1.4 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын үнэт цаасанд 35.7% буюу 759.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Зураг 9 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая.төг/




Богино хугацаат хөрөнгө оруулалтын 75.1 хувийг хувьцаагаарх, 20.8 хувийг өрийн бичгээр, 2.5 хувийг Засгийн газрын бондоорх үлдсэн 1.6 хувийг бусад хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

- Факторингийн тооцооны авлага, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, бусад хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө

Факторингийн тооцооны авлага 232.7 сая төгрөгийн хэвийн үлдэгдэлтэй байна.

Өмчлөх бусад хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1.0 тэрбум төгрөгөөр өсөж 1.9 тэрбум төгрөгт, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө 3.9 тэрбум төгрөгөөр өсөж 10.8 тэрбум төгрөгт хүрч тэдгээрт нийт 2.9 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Зураг 10 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



Бусад хөрөнгө оны эхнээс 33.8% буюу 25.5 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 49.2% буюу 33.4 тэрбум төгрөгөөр өсөж 101.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 8.8 хувийг бүрдүүлж байна. 2018 оны II улирлын байдлаарх бусад

хөрөнгийн 42.6 хувийг хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 25.7 хувийг цэвэр авлага, 31.7 хувийг бусад актив бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 539 ББСБ-ын 52.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөнд 9.7 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 9 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2017- II	2018- II	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
<i>Үндсэн ба биет бус хөрөнгө</i>	43.7	52.4	8.6	19.8%
Барилга байгууламж	16.1	18.7	2.6	16.1%
Техник хэрэгсэл	14.6	18.4	3.8	26.2%
Тавилга эд хогшил	5.7	6.5	0.8	13.3%
Дуусаагүй барилга	3.2	4.5	1.2	38.1%
Биет бус хөрөнгө	4.1	4.3	0.3	6.1%
<i>Хуримтлагдсан элэгдэл</i>	7.6	9.7	2.1	27.6%
Барилга байгууламжийн	0.9	1.4	0.5	58.6%
Техник хэрэгслийн	4.8	6.1	1.3	26.5%
Тавилга эд хогшлын	2.0	2.3	0.3	16.5%
ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	36.1	42.6	6.5	18.1%

2.2 Зээл

2018 оны II улирлын байдлаар 490 ББСБ нь 768.3 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй, 150,542 зээлдэгчид зээлийн үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь нийт активын 67.2%, эргэлтийн хөрөнгийн 69.9 хувийг бүрдүүлж байна.


2.2.1 Зээлийн зориулалт

2017 оны жилийн эцэст 482 ББСБ-ын 637.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан ба 2018 оны I хагас жилд 433 ББСБ нийт 575.2 тэрбум төгрөгийн зээл олгосон бол 442 ББСБ-ын 444.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж 2018 оны II улирлын байдлаар 470 ББСБ-ын 768.3 тэрбум төгрөгийн зээлийн эцсийн үлдэгдэлтэй гарчээ.

Олгосон зээлийн 82.1% буюу 472.2 тэрбум төгрөгийг 427 ББСБ иргэдэд


олгосон бол 17.9% буюу 103.0 тэрбум төгрөгийг 146 ББСБ хуулийн этгээдэд олгосон байна.

Зураг 11 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/



Олгосон болон төлөгдсөн зээлийг авч үзвэл, хэрэглээний зээлд 288.9 тэрбум төгрөгийн зээл олгож, 226.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн, худалдааны салбарт 108.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 89.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгджээ.

Зураг 12 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/



2.2.2 Зээлийн багцын чанар

Нийт зээлийн 653.8 тэрбум төгрөг буюу 85.1 хувийг хэвийн зээл, 34.4 тэрбум төгрөг буюу 4.5 хувийг хугацаа хэтэрсэн


зээл, 80.2 тэрбум төгрөг буюу 10.4 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба чанаргүй зээлийн 72.1 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна.

Хүснэгт 10 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/

Зээлийн чанарын ангилал	2017-II	2017-IV	2018-II	Өөрчлөлт	
				оны эхэн	өмнөх оны мөн үе
				дүн	дүн
Хэвийн	449.8	527.0	653.8	24.1%	45.3%
Хугацаа хэтэрсэн	33.0	29.9	34.4	15.2%	4.4%
Чанаргүй:	72.2	81.1	80.2	-1.2%	11.1%
Хэвийн бус	12.5	17.6	17.1	-3.0%	36.2%
Эргэлзээтэй	18.1	14.2	17.8	25.6%	-1.4%
Муу	41.6	49.3	45.3	-8.2%	8.9%
(Зээлийн эрсдэлийн сан)	-47.4	-56.0	-57.8	3.2%	22.0%
Нийт зээл	554.9	638.0	768.3	20.4%	38.5%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	507.6	582.0	710.6	22.1%	40.0%
Нийт зээл (төгрөгийн)	518.8	605.3	743.0	22.7%	43.2%
Нийт зээл (валютын)	36.2	32.7	25.4	-22.5%	-29.9%

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үед 13.0% байсан бол 2018 оны эхний хагас жилийн байдлаар 10.4% болж 2.6 функтээр буурсан дүнтэй гарчээ.


Зураг 13 Зээлийн чанар



Чанаргүй зээлийн хэмжээ оны эхнээс 1.2 хувиар буюу 0.9 тэрбум төгрөгөөр буурсан, хугацаа хэтэрсэн зээл 15.2% буюу 4.5 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд

нийт зээлд эзлэх чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ харгалзан өмнөх оны мөн үеэс 2.6, 1.5 функтээр, оны эхнээс 2.3, 0.2 функтээр тус тус буурсан бол хэвийн зээл 24.1% буюу 126.8 тэрбум төгрөгөөр өсөж нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.0 функтээр, оны эхнээс 2.5 функтээр тус тус өссөн байна.

Зураг 14 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа



Нийт зээлийн эцсийн үлдэгдэлд эзлэх валютын зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 функтээр, оны эхэнтэй харьцуулахад 1.7 функтээр буурсан дүнтэй гарчээ.

2.2.3 Зээлдэгчид


Хүснэгт 11 Ерөнхий статистик /харилцагчид/

Харилцагчдын мэдээлэл	Дүн	Хувь
Нийт харилцагчдын тоо	1,423,597	100.0%
Үүнээс: Эмэгтэй	685,267	48.1%
Хуулийн этгээд	1,597	0.1%
Зээлдэгчдийн тоо	150,542	100.0%
Хэвийн	132,652	88.1%
Хугацаа хэтэрсэн	10,187	6.8%
Чанаргүй:	7,703	5.1%
Хэвийн бус	2,307	1.5%
Эргэлзээтэй	2,178	1.4%
Муу	3,218	2.1%
Зээлдэгчдийн насжилт	149,203	100.0%
18-35 насны	76,560	51.3%
36-45 насны	44,681	29.9%
46-55 насны	21,013	14.1%
55-аас дээш	6,949	4.7%
Зээлдэгчдийн боловсрол	149,142	100.0%
-Дээд	93,181	62.5%
-Тусгай дунд	11,981	8.0%
-Бүрэн дунд	31,139	20.9%
-Дунд	12,180	8.2%
-Бага	661	0.4%

2018 оны II улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 490 ББСБ-ын 150,542 зээлдэгч бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрийн 88.1% буюу 132,652 нь хэвийн, 6.8% буюу 10,187 хугацаа хэтэрсэн, 1.5% буюу 2,307 нь хэвийн бус, 1.4% буюу 2,178 нь эргэлзээтэй, 2.1% буюу 3,218 муу зээлдэгчид байна.

Насжилтын хувьд авч үзвэл нийт зээлдэгчдийн 81.3% буюу 121,241 нь 18-45 насны, 14.1% буюу 21,013 нь 46-55 насны, 4.7% буюу 6,949 нь 55-аас дээш насны иргэд байна.

Зураг 15 Зээлдэгчдийн боловсрол




Боловсролын төвшнөөр дээд болон тусгай дунд боловсролтой иргэд нийт зээлдэгчдийн 105,162 буюу 70.5 хувийг бүрдүүлж байгаа бол бүрэн дунд боловсролтой иргэд 31,139 буюу 20.9 хувийг, бага болон дунд боловсролтой иргэд 12,841 буюу 8.6 хувийг бүрдүүлж байна.

2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү

2018 оны II улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 490 ББСБ-аас 433 ББСБ нийт 575.2 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд олгосон зээлийн дээд хүү 10.7%, доод хүү 1.0%, жигнэсэн дундаж хүү 3.3% байна.

ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3%-тай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 пунктээр буусан үзүүлэлт юм. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 1.8 пунктээр өндөр гарсан байна.

Зураг 16 Зээлийн жигнэсэн дундаж хүү



3. Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт хөрөнгийн 22.3% буюу 255.2 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 77.7% буюу 888.5 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

2018 оны II улирлын байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 12 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/

Хөрөнгө	2017-II	2017-IV	2018-II	Өөрчлөлт			
				Оны эхнээс		Өмнөх оны мөн үеэс	
				Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар
Өр төлбөр	174,380.9	211,011.1	255,219.3	44,208.2	21.0%	80,838.34	46.4%
Санхүүгийн эх үүсвэр	34,545.3	39,217.7	45,591.4	6,373.6	16.3%	11,046.09	32.0%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	92,052.1	112,761.7	133,729.1	20,967.4	18.6%	41,677.08	45.3%
Бусад эх үүсвэр	3,525.3	6,711.2	9,018.2	2,307.0	34.4%	5,492.89	155.8%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	4,313.9	6,876.9	16,687.2	9,810.3	142.7%	12,373.29	286.8%
Төслийн зээлийн санхүүжилт	16,307.6	14,869.9	16,560.8	1,690.9	11.4%	253.17	1.6%
Бусад өр төлбөр	23,636.8	30,573.7	33,632.6	3,058.9	10.0%	9,995.83	42.3%
Эздийн өмч	681,406.3	758,167.9	888,477.1	130,309.2	17.2%	207,070.73	30.4%
Хувьцаат капитал	549,479.6	595,389.1	707,799.1	112,409.9	18.9%	158,319.49	28.8%
Бусад өмч	8,245.8	6,570.8	8,412.4	1,841.6	28.0%	166.59	2.0%
Сангууд	596.4	429.6	438.1	8.5	2.0%	(158.27)	-26.5%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	122,378.0	155,071.8	170,860.9	15,789.2	10.2%	48,482.93	39.6%
Хоёрдогч өглөг	706.6	706.6	966.6	260.0	36.8%	260.00	36.8%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	855,787.28	969,179.00	1,143,696.36	174,517.4	18.0%	287,909.08	33.6%

3.1 Өр төлбөр

ББСБ-ын өр төлбөрийн хэмжээ 2018 оны II улиралд өмнөх оны мөн үеэс 80.8 тэрбум төгрөгөөр буюу 46.4 хувиар, оны эхнээс 44.2 тэрбум төгрөгөөр буюу 21.0 хувиар өсөж нийт өр төлбөрийн хэмжээ 255.2 тэрбум төгрөг хүрсэн байна.

- Итгэлцлийн үйлчилгээний өглөг


Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 29 ББСБ-ын 21 нь 45.6 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт пассивын 4.0 хувьтай тэнцэж байна.

10 ББСБ 1 тэрбум төгрөг хүртэлх дүнгээр 3.6 тэрбум төгрөгийн, 11 ББСБ 1 тэрбум төгрөгөөс дээш дүнгээр 42.0 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн 45.6 тэрбум төгрөгийн 82.8%

буюу 37.8 тэрбум төгрөгийг 20 ББСБ төгрөгөөр, 17.2% буюу 7.8 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 10 ББСБ валютаар татан төвлөрүүлсэн байна.

Зураг 17 Итгэлцлийн үйлчилгээний өглөг



- Дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2018 оны II улирлын байдлаар 69 ББСБ дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагын 133.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт хөрөнгийн 11.7 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 41.6 тэрбум төгрөгөөр буюу 45.3 хувиар, оны эхнээс 20.9 тэрбум төгрөгөөр буюу 18.6 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 13 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/

Авсан зээлийн хэмжээ	ББСБ-ын тоо	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн хэмжээ
1 тэрбумаас дээш	18	88.1%	81.8
0.1-0.9 тэрбум	31	11.0%	10.2
0.1 тэрбумаас доош	18	0.9%	0.9
НИЙТ	67	100.00%	92.9

Хүснэгт 14 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/

Авсан зээлийн хэмжээ	ББСБ тоо	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн хэмжээ
10 тэрбумаас дээш	1	67.8%	27.7
1-9 тэрбум	2	27.3%	1.2
1 тэрбумаас доош	4	4.8%	1.9
НИЙТ	7	100%	40.8

Банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн 69.5 хувийг дотоодын, 30.5 хувийг гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл эзэлж байна. Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас 67 ББСБ 92.9 тэрбум төгрөг, гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас 7 ББСБ 40.8 тэрбум төгрөгийн зээл татан төвлөрүүлсэн байна.

- Бусад эх үүсвэр


Хүснэгт 15 Мөнгөн гуйвуулга болон төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй ББСБ-ууд /мян.төг/

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй ББСБ-ууд		
1	“Мониполо ББСБ” ХХК	3,505,105.32
2	“Паблик кредит ББСБ” ХХК	1,796,320.97
3	“Шинэ төгрөг ББСБ” ХХК	294,505.04
4	“Сайн финанс энд трансфер ББСБ” ХХК	150,197.02
5	“Наран сансар ББСБ” ХХК	124,397.59
6	“Зэт пэй ББСБ” ХХК	2,951.80
7	“Мөнгөн гүүр ББСБ” ХХК	250.00
8	“Эф эс өү эс ББСБ” ХХК	188.85
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй ББСБ		
1	“Мобифинанс ББСБ” ХХК	3,144,262.06

Бусад эх үүсвэр нийт пассивын 0.8% буюу 9.0 тэрбум төгрөгийг бүрдүүлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 2.6 дахин буюу 5.5

тэрбум төгрөгөөр, оны эхнээс 34.4% буюу 2.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ.

Зураг 18 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/



2018 оны II улирлын байдлаар бусад эх үүсвэрийн 68.3% буюу 6.6 тэрбум төгрөгийг нийт цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 23 ББСБ-аас 8 ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээний 5.9 тэрбум төгрөгийн өглөгтэй, 1 ББСБ төлбөр тооцооны үйлчилгээний 3.1 тэрбум төгрөгийн өглөгтэй гарчээ.

- ББСБ-аас гаргасан өрийн бичиг

2018 оны II улирлын байдлаар 14 ББСБ 16.7 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргасан нь өмнөх оны мөн үеэс 3.9 дахин буюу 12.4 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 2.4 дахин буюу 9.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Энэ өсөлтөд 6 ББСБ-ын нэмж гаргасан 8.7 тэрбум төгрөгийн төгрөгөөрх, 0.8 тэрбум төгрөгийн валютаарх өрийн бичгүүдийн өсөлт нөлөөлсөн байна.

- Төслийн зээл санхүүжилт

2018 оны II улиралд 35 ББСБ 16.6 тэрбум төгрөгийн төслийн зээлтэй байгаа нь нийт хөрөнгийн 1.4 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 1.6% буюу 0.3 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 11.4% буюу 1.7 тэрбум төгрөгөөр өсжээ.

Төслийн санхүүжилтийн 96.3% буюу 15.9 тэрбум төгрөгийг төгрөгийн, 3.7% буюу 0.6 тэрбум төгрөгийг валютын зээл эзэлж байна.

Зураг 19 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/




Богино хугацаат санхүүжилтээр 12 ББСБ 4.3 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байгаа бол урт хугацаат санхүүжилтээр 25 ББСБ 12.3 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан байна.

Төслийн зээлийн 6.6 тэрбум төгрөгийг гадаад байгууллагаас, 7.1 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагаас, 0.8 тэрбум төгрөгийг Засгийн газрын төслийн зээлийн эх үүсвэрээс, 2.1 тэрбум төгрөгийг бусад санхүүжилтээс бүрдүүлсэн байна.

- Бусад өр төлбөр

2018 оны II улирлын байдлаар 475 ББСБ 33.6 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь нийт пассивын 2.9 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 42.3% буюу 9.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 10.0% буюу 3.1 тэрбум төгрөгөөр өссөн дүн байна.

Зураг 20 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг



Бусад өр төлбөрийн 82.8% буюу 27.9 тэрбум төгрөгийг бусад пассив, 17.2% буюу 5.8 тэрбум төгрөгийг хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг бүрдүүлж байна.

Бусад пассивын задаргаа:


Хүснэгт 16 Бусад пассив /сая төгрөгөөр/

Төрөл	Дүн	Эзлэх хувь
БУСАД ПАССИВ	27,863.5	100.0%
Бусад өглөг	20,428.5	73.3%
Татварын өглөг	5,277.9	18.9%
Ногдол ашгийн өглөг	1,105.8	4.0%
Салбар хоорондын тооцооны өглөг	557.9	2.0%
Цалингийн өглөг	245.9	0.9%
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	227.8	0.8%
Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өглөг	19.7	0.1%

3.2 Эздийн өмч

Сүүлийн 5 жилийн II улирлын байдлаар нийт ББСБ-уудын өр төлбөр нийт хөрөнгийн хэмжээнд эзлэх хувь хэмжээ буурсан үзүүлэлт ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь ББСБ-ууд өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж байгаагаар холбоотой. ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хэмжээ 2017 оны IV улиралд 61.4 хувийг бүрдүүлж байсан бол 2018 оны II улиралд 61.9 хувийг бүрдүүлж байна.

Зураг 21 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



Өөрийн хөрөнгийн 79.7% буюу 707.8 тэрбум төгрөг нь хувь нийлүүлсэн хөрөнгө, 19.2% буюу 170.9 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг, 0.9% буюу 8.4 тэрбум төгрөгийг бусад өмч, 0.1% буюу 0.97 тэрбум төгрөгийг хоёрдогч өглөг, 0.05% буюу 0.4 тэрбум төгрөгийг сангууд бүрдүүлж байна.

2018 оны II улирлын байдлаар өөрийн хөрөнгийн голлох өөрчлөлтүүдийг харвал хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ оны эхнээс 18.9% буюу 112.4 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 28.8% буюу 158.3 тэрбум төгрөгөөр, хуримтлагдсан ашиг оны эхнээс 10.2% буюу 15.8 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 39.6% буюу 48.5 тэрбум төгрөгөөр, хоёрдогч өглөгөөр татсан эх 36.8% буюу 260.0 сая төгрөгөөр өсжээ.

Эхний хагас жилд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх тогтоолын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй 286 ББСБ 100.4 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлжээ.

2018 оны II улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 66 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 38.6 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.0-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 345 ББСБ 57.0 хувийг эзэлж байгаа бол 0.9 тэрбумаас доош хөрөнгөтэй 128 ББСБ 4.4 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 17 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/

Интервал	ББСБ тоо	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
0.9 тэрбумаас доош	128	23.7%	31.3	4.4%
1.0-1.8 тэрбум хүртэл	314	58.3%	337.9	47.7%
1.9-2.4 тэрбум хүртэл	31	5.8%	65.6	9.3%
2.5-4.9 тэрбум хүртэл	51	9.5%	149.8	21.2%
5 тэрбум ба түүнээс дээш	15	2.8%	123.2	17.4%
НИЙТ	539	100.0%	707.8	100.0%

4. Орлого, үр дүнгийн тайлан

2018 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 118.4 тэрбум төгрөгийн орлого олж, 71.9 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 46.5 тэрбум төгрөгийн ашиг олжээ.


Зураг 22 Ашигт ажиллагааны үзүүлэлт



4.1 Орлого

2018 оны II улирлын байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.5% буюу 29.0 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ. Хүүгийн орлого 24.8 тэрбум төгрөгөөр, хүүгийн бус орлого 1.9 тэрбум төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлого 2.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 23 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/



- Хүүгийн орлого

Хүүгийн орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар буюу 24.8 тэрбум төгрөгөөр өсөж 99.2 тэрбум төгрөгт хүрсэн

ба нийт орлогын 83.7 хувийг бүрдүүлж байна.


473 ББСБ 99.2 тэрбум төгрөгийн хүүгийн орлогын дүнтэй гарсан байна.

Хүүгийн орлогыг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн 97.4 тэрбум төгрөгийн орлого, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн 3.4 тэрбум төгрөгийн орлого, үнэт цаасны хүүгийн 84.5 сая төгрөгийн орлого, -1.7 тэрбум төгрөгийн бусад хүүгийн орлого бүрдүүлж байна.

- Хүүгийн бус орлого

Хүүгийн бус орлого нь 2018 оны II улирлын байдлаар нийт орлогын 11.8% буюу 13.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 16.1% буюу 1.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт байна.

Зураг 24 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/



Гадаад валют арилжааны орлого 254.4 сая төгрөгөөр буурч 1.9 тэрбумд хүрсэн бол гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого 2.0 тэрбум төгрөгөөр буурч 2.9 тэрбум төгрөг, санхүүгийн үйлчилгээний орлого 1.9 дахин буюу 4.2 тэрбум төгрөгөөр өссөн эерэг үр дүн үзүүлсэн байна.

Хүснэгт 18 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая,төг/

Санхүүгийн үйлчилгээний орлого	2017-I	2018-I	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Итгэлцлийн үйлчилгээний орлого	0.0	2.3	2.3	-
Мөнгөн гуйвуулгын орлого	336.9	676.2	339.3	2 дахин
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	77.4	75.8	-1.6	-2.1%
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2575.3	5627.2	3051.9	1.2 дахин
Бусад	1791.1	2623.3	832.2	46.5%
НИЙТ	4,780.8	9,004.9	4,224.1	44.4%


Санхүүгийн үйлчилгээний орлогын өсөлтөд үйлчилгээ хураамж шимтгэлийн орлого 2.2 дахин буюу 3.1 тэрбум

төгрөгөөр, мөнгөн гуйвуулгын орлого 2.0 дахин буюу 339.3 сая төгрөгөөр, бусад орлого 1.5 дахин буюу 832.2 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

- Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт орлогын 4.5 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 тэрбум төгрөг буюу 67.7 хувийн өсөлттэй байна.

Зураг 25 Үндсэн бус үйл ажиллагааны орлого



4.2 Зарлага

2018 оны II улиралд 71.9 тэрбум төгрөгийн зардалтай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.2 хувиар өссөн үзүүлэлт байна.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал, 93.9% буюу 0.7 тэрбум төгрөгөөр, орлогын албан татварын зардал 59.3% буюу 2.1 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ.

Хүснэгт 19 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2017- II	2018- II	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Хүүгийн зардал	6.9	9.2	2.3	33.04%
Хүүгийн бус зардал	40.0	44.1	4.2	10.47%
Болзошгүй эрсдэлийн зардал	10.2	11.4	1.3	12.31%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.8	1.5	0.7	93.94%
Орлогын албан татварын зардал	3.5	5.7	2.1	59.34%
Нийт зарлага	61.4	72.0	10.6	2.1

- Хүүгийн зардал

Хүүгийн зардал нийт зардлын 12.8% буюу 9.2 тэрбум төгрөг байна. 2017 оны мөн үеийн дүнтэй харьцуулахад 33.0% буюу 2.3 тэрбумаар өссөн байна.

- Хүүгийн бус зардал

Хүүгийн бус зардал нь 44.1 тэрбум төгрөг буюу нийт зардлын 61.3 хувийг бүрдүүлж байна. 2017 оны мөн үетэй харьцуулахад 10.5% буюу 4.2 тэрбум төгрөгөөр өсжээ.

- Болзошгүй эрсдэлийн зардал

Нийт зардлын 15.9% буюу 11.4 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал бүрдүүлж байгаа ба энэ зардал нь өмнөх оны мөн үеэс 12.3% буюу 1.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарсан байна. Үүнд зээлийн эрсдэлийн зардал 18.0% буюу 1.6 тэрбум төгрөгөөр, авлагын эрсдэлийн зардал 13.8 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал 327.5 сая төгрөгөөр буурчээ.

- Үндсэн бус үйл ажиллагааны зардал


Нийт зардлын 2.1 хувийг үндсэн бус үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 93.9% буюу 728.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ.

4.3 Ашигт ажиллагаа

2018 оны II улиралд ББСБ-ууд 46.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 18.4 тэрбум төгрөгөөр буюу 65.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

2018 оны II улиралд 539 ББСБ-ын 434 нь буюу 80.5% нь 51.5 тэрбум төгрөгийн ашигтай, 89 нь буюу 16.5% нь 5.0 тэрбум төгрөгийн алдагдалтай, 16 нь буюу 3.0% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Зураг 26 Ашигийн өсөлт /хувиар/




5. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2018 оны II улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 539 ББСБ-ын 85.3% буюу 460 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 14.7% нь буюу 79 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 47 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 26 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 5 ба түүнээс дээш зохистой харьцаа алдагдсан 2 ББСБ байна.

Зураг 27 Зохистой харьцаа



5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 20 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	43	87.8%
1 зохистой харьцааг хангаагүй	1	2.0%
2 зохистой харьцааг хангаагүй	5	10.2%
3 зохистой харьцааг хангаагүй	-	-
4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	-	-
НИЙТ	49	100%

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 45 ББСБ хангасан буюу биелэлт 91.8%;

2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлагыг 44 ББСБ хангасан буюу биелэлт 89.8%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн хангасан;
5. Үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу 98.0%;
6. Өөрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Эдгээр 49 ББСБ-уудын хувьд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шалгуур үзүүлэлт хамгийн ихээр алдагдсан байна.

5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 21 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	376	85.3%
1 зохистой харьцааг хангаагүй	41	9.3%
2 зохистой харьцааг хангаагүй	19	4.3%
3 зохистой харьцааг хангаагүй	2	0.5%
4 зохистой харьцааг хангаагүй	1	0.2%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	2	0.5%
НИЙТ	441	100%

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 428 ББСБ хангасан буюу биелэлт 97.1%;

2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 429 ББСБ хангасан буюу биелэлт 97.3%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 439 ББСБ хангасан буюу биелэлт 99.5%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 431 ББСБ хангасан буюу биелэлт 97.7 хувь;
5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний зөрүү 0 байх шаардлагыг 439 ББСБ хангасан буюу биелэлт 99.5%;
6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 422 ББСБ хангасан буюу биелэлт 95.9%;
7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 435 ББСБ хангасан буюу биелэлт 98.6%;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 436 ББСБ хангасан буюу биелэлт 98.9%;
9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
10. Нэг компаниас худалдан авах үнэт цаасны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
11. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага 440 ББСБ хангасан буюу биелэлт 99.8%;
12. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас

хэтрэхгүй байх шаардлага 424 ББСБ хангасан буюу биелэлт 96.1%;

13. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг 427 ББСБ хангасан буюу биелэлт 96.8% хувь;

14. Өөрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх 441 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа үзүүлэлтүүдийг 10-18 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Хүснэгт 22 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШУ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	41	83.7%
1 зохистой харьцааг хангаагүй	5	10.2%
2 зохистой харьцааг хангаагүй	2	4.1%
3 зохистой харьцааг хангаагүй	1	2.0%
4 зохистой харьцааг хангаагүй	0	0%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	0	0%
НИЙТ	49	100%

Журмын 3.4-т заасан хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;

2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 93.9%;
5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг 48 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;
6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 95.8%;
7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 10 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
10. Худалдан авах хувьцааны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 95.9%;
11. Нэг компаниас худалдан авах хувьцааны төвлөрлийн үзүүлэлт өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
12. Өрийн бичгийн эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
14. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
15. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 93.9%;
16. Итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн зохистой харьцаа 80 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0%;
17. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 95.9%;
18. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй айх шалгуур үзүүлэлтийг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0% хангаж ажилласан байна.

Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх 49 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтүүдийг 3 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд

- Ерөнхий статистик

Тайлант онд хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 75 ББСБ, 180 хувьцаа эзэмшигч, 189 ажилтан, 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 7287 харилцагч, 6039 зээлдэгчдэд хүрч ажиллаж байна.

Хамгийн олон ББСБ-тай аймгууд нь Төв аймаг 11, Дорнод аймаг 8, Орхон аймагт 7 ББСБ тус тус байршиж байна.

Зураг 28 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт



Хүснэгт 23 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны төрөл	ББСБ тоо
1	Зээл	72
2	Гадаад валютын арилжаа	6
3	ХОСЧЗМӨ	2
4	Итгэлцлийн үйлчилгээ	1
5	Төлбөрийн баталгаа гаргах	1
НИЙТ		82

ББСБ-ын 5 төрлийн 82 тусгай зөвшөөрлийн хүрээнд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. 29 ББСБ буюу 38.7% нь санхүүгийн програмтай байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 91.6% нь хэвийн, 1.8% нь хугацаа хэтэрсэн, 6.6% нь чанаргүй зээлдэгчид байна.

ББСБ-уудын зээлдэгчдийн насжилтаар авч үзвэл орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 72.3 хувийг 18-45 насны,

19.1 хувийг 46-55 насны, 6.6 хувийг 55-аас дээш насны иргэд эзэлж байна. Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой иргэд 43.1%, тусгай дунд болон бүрэн дунд боловсролтой иргэд 45.2%, бага болон дунд боловсролтой иргэд 11.7 хувийг бүрдүүлж байна.

- Актив

Салбарын нийт активын 2.3 хувийг бүрдүүлж байгаа орон нутгийн ББСБ-уудын 26.5 тэрбум төгрөгийн актив хөрөнгийн 5.5 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, 537.5 сая төгрөг нь богино хугацаат хөрөнгө оруулалт цэврээр/, 18.1 тэрбум нь зээл /цэврээр/, 129.6 тэрбум төгрөг нь өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр), 1.4 тэрбум төгрөгийг бусад хөрөнгө бүрдүүлж байгаа ба үндсэн ба биет бус


хөрөнгө цэврээр 774.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 24 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	25,672.84	96.93%
Мөнгөн хөрөнгө	5,493.17	20.74%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	537.55	2.03%
Нийт зээл	22,835.14	86.22%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,722.29	17.83%
Зээл (цэврээр)	18,112.85	68.39%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	-	0.00%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	129.58	0.49%
Бусад хөрөнгө	1,399.69	5.28%
Эргэлтийн бус хөрөнгө	813.04	3.07%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	1,156.46	4.37%
(Хуримтлагдсан элэгдэл)	343.42	1.30%
Нийт хөрөнгийн дүн	26,485.88	100.00%

Зээлийн хувьд 17.5 тэрбум төгрөгийн хэвийн зээл, 332.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 5.0 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Зээлийн эрсдэлийн санг чанаргүй зээлийн 94.9 хувьд байгуулжээ.

Зураг 29 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



1.2 тэрбум төгрөгийн үндсэн (биет) ба биет бус хөрөнгөнд 343.4 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.

- **Пассив**

Орон нутгийн 75 ББСБ-ын хөрөнгийн 89.8% буюу 23.8 тэрбум төгрөг нь эздийн өмч, 10.2% буюу 2.7 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. Орон нутгийн ББСБ-уудын нийт хөрөнгийн 85.1 хувийг буюу 22.6

тэрбум төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдүүлж байгаа ба энэ нь салбарын хувьцаат капиталын 3.2 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 25 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум.төг/	Дүн	Хувь
Өр төлбөр	2.71	10.23%
Санхүүгийн эх үүсвэр	1.28	4.82%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	0.33	1.25%
Төслийн зээлийн санхүүжилт	0.69	2.61%
Бусад өр төлбөр	0.41	1.55%
Эздийн өмч	23.78	89.77%
Хувьцаат капитал	22.55	85.14%
Бусад өмч	0.32	1.22%
Сангууд	0.34	1.30%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	0.56	2.12%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	26.49	100.00%

- **Орлого үр дүнгийн тайлан**

2018 оны II улиралд орон нутгийн ББСБ-ууд 16.0 тэрбум төгрөгийн орлоготой, 14.1 тэрбум төгрөгийн зарлагатай, 1.9 тэрбум төгрөгийн цэвэр орлоготой ажиллаа. Орлогын 85.7 хувийг хугацаандаа байгаа хүүгийн орлого бүрдүүлж байна. Нийт зардлын 63.5% буюу 9.0 тэрбум төгрөгийг хүүгийн бус зардал /үүнээс боловсон хүчний холбогдолтой зардал 2.8 тэрбум, бусад зардал 2.8 тэрбум/, 8.0% буюу 1.1 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал /үүнээс зээлийн эрсдэлийн зардал 895.1 сая/ эзэлж байна.

6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ

- **Ерөнхий статистик**

Хүснэгт 26 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл

Үйл ажиллагааны төрөл	ББСБ-ын тоо
Зээл	27
Факторингийн үйлчилгээ	1
Төлбөрийн баталгаа гаргах	4
Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	1
Гадаад валютын арилжаа	11
Итгэлцлийн үйлчилгээ	2
Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	1
Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	3
НИЙТ	50

Тайлант улиралд гадаадын хөрөнгө оруулалттай 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай, 11 улсын, 66 хувьцаа эзэмшигчийн 27 ББСБ, 8 төрлийн 50 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь салбарын ББСБ-ын тооны 5.0 хувийг эзэлж байна.

- **Актив**

Гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ-ын хөрөнгө 141.3 тэрбум төгрөг нь нийт хөрөнгийн 12.4 хувийг бүрдүүлж байна.

Активын 69.43% буюу 98.1 тэрбум төгрөг нь цэвэр зээл, 17.37% буюу 24.5 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байгаа бол мөнгөн хөрөнгийн 25.5% буюу 6.3 тэрбум төгрөг нь кассанд, 36.3% буюу 8.9 тэрбум төгрөг нь харилцах дансанд, 38.2% буюу 9.4 тэрбум төгрөг нь хадгаламжийн дансанд тус тус байршиж байна.

- **Пассив**

Пассивын 48.0% буюу 67.8 тэрбум төгрөгийг өр төлбөр, 52.0% буюу 73.4 тэрбум төгрөгийг эздийн өмч эзэлж байна.

Хүснэгт 27 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	Дүн	Хувь
Өр төлбөр	67.8	48.0%
Санхүүгийн эх үүсвэр	8.3	5.9%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	45.4	32.1%
Бусад эх үүсвэр	3.5	2.5%
Төслийн зээлийн санхүүжилт	6.7	4.8%
Бусад өр төлбөр	3.9	2.8%
Эздийн өмч	73.4	52.0%
Хувьцаат капитал	62.0	43.9%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	10.2	7.2%
Эздийн өмчийн бусад хэсэг	1.2	0.9%
НИЙТ ПАССИВ	141.3	100.0%

Нийт 539 ББСБ-ын пассивын бүтэц нь эздийн өмч давамгайлсан бүтэцтэй байдаг бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд өр төлбөр болон эздийн өмчийн харьцаа ойролцоо дүнтэй байна. Өр төлбөрийн 66.8% нь дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл байгаа бол эздийн өмчийн 84.3% нь хувьцаат капитал байна.

Дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн 37.3% буюу 16.9 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагуудаас, 62.7% буюу 28.5 тэрбум төгрөгийг гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас авсан өр төлбөр эзэлж байна.

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ 16.3 тэрбум төгрөгийн орлоготой, 14.2 тэрбум төгрөгийн зарлагатай, 2.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

6.3 Гадаад валютын арилжааны ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж байгаа ББСБ-ууд нь нийт ББСБ-уудын 8.5%, гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудын 30.3% буюу 46 ББСБ, 6 салбар, 136 ажилтан, 22,723 харилцагчдад хүрч үйл ажиллагаа эрхэлж байна.

Гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 152 ББСБ байгаагаас дагнан эрхэлж байгаа 46 ББСБ-уудын 43 нь Улаанбаатар хотод, 3 ББСБ орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

- **Актив**

Хүснэгт 28 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	10,667,742.74	98.17%
Мөнгөн хөрөнгө	10,563,852.08	97.22%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,000.00	0.01%
Бусад хөрөнгө	102,890.66	0.95%
Эргэлтийн бус хөрөнгө	198,629.18	1.83%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	311,126.72	2.86%
(Хуримтлагдсан элэгдэл)	-112,497.54	-1.04%
НИЙТ ХӨРӨНГӨ	10,866,371.92	100.00%

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын нийт активын хэмжээ 10.9 тэрбум төгрөг байгаа нь салбарын активын 1.0% байна. Үйл ажиллагааны онцлогоос хамааран нийт активын 97.2% нь мөнгөн хөрөнгө, 0.01% нь богино хугацаат хөрөнгө оруулалт, 0.9% нь бусад

хөрөнгө байгаа бөгөөд 1 ББСБ 1 сая төгрөгийн засгийн газрын арилжааны үнэт цаас худалдаж авсан байна.

- **Пассив**

Нийт хөрөнгийн 93.9% буюу 10.2 тэрбум төгрөг нь хувьцаат капитал, 4.8% буюу 517.3 сая төгрөг нь хуримтлагдсан ашиг, 1.1% буюу 123.4 сая төгрөг нь өр төлбөр, 0.2% буюу 20.7 сая төгрөг нь бусад өмч байна.

Хүснэгт 29 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Өр төлбөр	123,433.59	1.14%
Хувьцаат капитал	10,204,862.40	93.91%
Бусад өмч	20,747.70	0.19%
Хуримтлагдсан ашиг	517,328.24	4.76%
Нийт пассив	10,866,371.93	100.00%

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд 658.2 сая төгрөгийн орлоготой, 633.5 сая төгрөгийн зарлагатай, 24.7 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

26 ББСБ 83.2 сая төгрөгийн цэвэр орлоготой, 18 ББСБ 58.5 сая төгрөгийн

алдагдалтай, 2 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй байна.


Хүснэгт 30 Орлогын бүтэц

НИЙТ ОРЛОГО	658,230.79	100.0%
Хүүгийн орлого	6,346.66	1.0%
Хүүгийн бус орлого	651,821.97	99.0%
Гадаад валютын арилжааны орлого	630,644.33	95.8%
Хани болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	21,133.98	3.2%
Санхүүгийн үйлчилгээний орлого	43.66	0.01%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	62.16	0.01%

Зарлагын бүтцийн хувьд 96.7% нь хүүгийн бус зардал, 1.4% нь үндсэн бус үйл ажиллагааны зардал, 1.9% нь орлогын албан татварын зардал байна.

Хүүгийн бус зардлын бүтцийг авч үзвэл:

Зураг 30 Хүүгийн бус зардлын бүтэц



ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс: 2018 оны II улиралд 443 ББСБ 853.09 сая төгрөгийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.
- Зээлийн мэдээллийн сан: Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 486 ББСБ-ын 88.2% буюу 442 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх: 2018 оны II улиралд Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 539 ББСБ-ын 68.6 хувь буюу 370 ББСБ хэрэгжүүлсэн байх тул Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.4 дэх хэсгийн “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

2018 оны II улиралд Хорооны ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа 539 ББСБ-ын 97.6% буюу 526 ББСБ санхүүгийн тайлан мэдээгээ бүрэн ирүүлсэн бол 5 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр, 8 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр 2018 оны II улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдлаа.

2018 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 4,793 хувь нийлүүлэгчдийн 539 ББСБ 190 салбар нэгж, 4 төлөөлөгчийн газар, 2602 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,423,597 харилцагчдад хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 464 ББСБ, 133 салбар Улаанбаатар хотод, 75 ББСБ, 57 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1,143.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.6 хувиар буюу 287.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 18 хувиар буюу 174.5 тэрбум төгрөгөөр өсөж банкны салбарын нийт активын 3.8 хувьтай тэнцэж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 361 ББСБ нийт активын 52.7 хувийг, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 36 ББСБ нийт активын 43.1 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 142 ББСБ нийт активын 4.3 хувийг бүрдүүлж байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 768.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 5.0 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 653.8 тэрбум төгрөг буюу 85.1 хувийг хэвийн зээл, 34.4 тэрбум төгрөг буюу 4.5 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 80.2 тэрбум төгрөг буюу 10.4 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба чанаргүй зээлийн 72.1 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна. Чанаргүй зээлийн хэмжээ оны эхнээс 1.2 хувиар буюу 0.9 тэрбум төгрөгөөр буурсан бол хэвийн зээл 24.1% буюу 126.8 тэрбум төгрөгөөр, хугацаа хэтэрсэн зээл 15.2% буюу 4.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 490 ББСБ-аас 433 ББСБ нийт 575.2 тэрбум төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгосон нь банкны салбартай харьцуулахад 1.8 пунктээр өндөр байна.

ББСБ-уудын пассивын бүтцийг харвал 77.7% буюу 888.5 тэрбум төгрөг нь өөрийн хөрөнгө, 23.3% буюу 255.2 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. 2018 оны II улирлын байдлаар

2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 66 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 38.6 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.0-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 345 ББСБ 57.0 хувийг эзэлж байгаа бол 0.9 тэрбумаас доош хөрөнгөтэй 128 ББСБ 4.4 хувийг бүрдүүлж байна.

2018 оны II улирлын байдлаар 539 ББСБ 118.4 тэрбум төгрөгийн орлоготой, 71.9 тэрбум төгрөгийн зарлагатай 46.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Үүнээс ББСБ-ын 434 нь буюу 80.5% нь 51.5 тэрбум төгрөгийн ашигтай, 89 нь буюу 16.5% нь 5.0 тэрбум төгрөгийн алдагдалтай, 16 нь буюу 3.0% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Нийт ББСБ-ын 85.3% буюу 460 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 79 ББСБ буюу 14.7% нь зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР